

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-11</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>12-21</i>
<hr/>	
<i>1. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>12-18</i>
<i>2. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>18-19</i>
<i>3. Монголбанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан сонсох</i>	<i>19-20</i>
<i>4. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.14-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>20-21</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 43 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Б.Жавхлан, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл;

Чөлөөтэй: С.Чинзориг;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баттөмөр.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорлоо нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Н.Ганибал, Ч.Ундрам, Т.Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 6.1.3 дахь заалтын “Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан бизнесийн ААНОАТ-ыг 5 хувь болгоно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.16 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Ховдын Дөргөн”- “Завханы Загастайн даваа”-ны урд яруугийн уулзвар чиглэлийн 375 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Ховд, Завхан) гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “3,187.50” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.17 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Алтай-Бургастай боомт чиглэлийн 253 км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “101,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 2000 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “17,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.19 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 200 км авто зам барих (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд “100,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Хожуулын голын гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “7,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.21 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Идэр голын 96 у/м төмөрбетон гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “8,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.22 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хүнгүйн голын 72 у/м төмөр бетон гүүр /Завхан, Ургамал сум/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “5,040.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.2.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Байдрагийн усан цахилгаан станц барих (Баянхонгор аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “30” гэж, Санхүүжилтэд “54,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Авто замын засвар арчлалтын ажилд шаардлагатай асфальтбетон завод, тоног төхөөрөмж худалдаж авах /Улсын хэмжээнд/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Тоног, төхөөрөмж” гэж, Хэмжих нэгжид “тоо” гэж, Суурь түвшинд “4” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “4,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Увс аймгийн Малчин сумын Засаг даргын Тамгын газрын барилга барих” Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.6. дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Үндэсний хиймэл дагуулын дэд бүтцийг байгуулах” гэснийг “Монгол Улсын Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөл хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Төслийн хэрэгжилт” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэснийг “75” гэж, Санхүүжилтэд “1,600.00” /Нэг тэрбум зургаан зуун сая/ гэснийг “568,716.33” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээ хийх, хүний нөөцийн аудитын ажлыг сайжруулах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Төрийн албаны зөвлөл” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх” гэснийг “Эмээлт Эко Аж Үйлдвэрийн паркийн дулаан болон цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Цахилгаан хангамжийн барилгын ажлын гүйцэтгэл” гэснийг “Ажлын гүйцэтгэл” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэснийг “25” гэж, Санхүүжилтэд “14,800.00” гэснийг “112,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлыг боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд “85,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвшлийн түншлэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Туул усан цогцолбор барих төслийг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “426,740.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвшлийн түншлэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Гадаадын тусламж, Улсын төсөв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Сэргээгдэх эрчим хүч бүхий дулаан автобусны буудал барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “9,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Гэр хорооллын далан дагуух авто зам төсөл хэрэгжүүлэх /Баянгол дүүргийн 21, 9, 10, 22 дүгээр хороо/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “10,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.3.3.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Баянгол дүүргийн Цагдаагийн газрын барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “13,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Хавдар судлалын Үндэсний төв-II байгуулах” гэснийг “Хавдар судлалын Үндэсний төв-II-ийн дэд бүтэц барилгын ажлыг эхлүүлэх” гэж, Санхүүжилтэд “100,000.00” гэснийг “110,000.00” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4

Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.7 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэснийг “Улсын төсөв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Улсын төсөв” гэснийг “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Яаралтай тусламжийн төв барих (Орхон аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “5,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагууд “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.8 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Орх, гэр эрүүл мэндийн төв барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Булган аймаг) гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж, мөн заалтын Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Хөвсгөл аймаг) гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.19 дэх дэд заалтын Төсөл арга хэмжээнд “”Мөрөн-Улиастай” чиглэлийн хатуу хучилттай авто

зам төсөл барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “10” гэж, Санхүүжилтэд “43,590.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр-хувийн хэвшлийн түншлэл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэнд хуульчдыг мэргэшүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Мэргэшүүлэх хуульчдын тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “1,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ХЗДХЯ” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулга бүхий дэд заалт шинээр нэмэх:

“4/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүйг ашиглаж, үр дүнг хангахад чиглэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монголбанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Монголбанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайланг Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайланг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.14-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн Б.Одбаатар, мөн газрын ахлах шинжээч Г.Чинсанаа, Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Г.Гантөр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын шинжээч Б.Амарбаясгалан, “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал Б.Эрдэнэбулган, мөн компанийн Хөрөнгө ашиглалт, зохицуулалтын

газрын дарга Ч.Маргад-Эрдэнэ, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Б.Азжаргал, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Түвшинтөгс, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Амартүвшин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ж.Түвшинжаргал, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 41 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
14 цаг 43 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож бай оролцож байгаа гишүүдийнхээ ирцийг танилцуулъя. Цэрэнпунцаг ирсэн, Батлут гишүүн ирсэн, Ганбаатар гишүүн ирсэн, Ганхуяг гишүүн ирсэн, Ганибал гишүүн ирсэн, Даваасүрэн гишүүн ирсэн, Доржханд гишүүн ирсэн, Оюунчимэг гишүүн ирсэн, Ундрэм гишүүн ирсэн, Хүрэлбаатар гишүүн ирсэн, Энхбаяр гишүүн ирсэн, Энхтүвшин ирсэн ирсэн байна. Ингээд байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 61,1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. 4 асуудал байна.

1 дүгээрт Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын 2024 оны 4 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

2.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр 2024 оны 2 сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

3.Монгол банкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлангууд

4.Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газрын 2024 оны 5 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ гэсэн 4 асуудал байна. Эхний 3 асуудал бол Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр энэ 7 хоногийн хэлэлцэх асуудлын тов дараалалд орсон байсан юм. Ингээд Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрээр Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өнөөдөр бас нэмж хэлэлцэхээр болсон байгаа юм. Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна. Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор “Монгол Улсын

хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар бэлтгүүлэх, бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ганибал, Ганхуяг, Ундрал, Энхтүвшин нар ажилласан болно. Ажлын хэсэг 1 удаа, дэд ажлын хэсэг 2 удаа хуралдаж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд заасан холбогдох шаардлагыг хангасан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай зарчмын зөрүүтэй 19 санал бэлтгэж та бүхэнд тараасан.

Тухайлбал, тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан бизнесийг ААНОАТ-ыг 5 хувь болгоно гэснийг хасахаар, мөн тогтоолын төслийн 2 дугаар хавсралт хөгжлийн ирээдүйтэй суурийг тодорхойлж, улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох, Монгол Улсын харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төслийг хэрэгжүүлэх, Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн үнэлгээ хийх, хүний нөөц, аудитын ажлыг сайжруулах, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дулаан болон цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх зэрэг төсөл арга хэмжээг тогтоолын төсөлд нэмж тусгахаар тэдгээрийн шалгуур үзүүлэлт болон зорилт, түвшин, хэмжих нэгж, хариуцах байгууллага зэрэгт холбогдох өөрчлөлтүүдийг оруулж бэлтгэсэн болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Ингээд ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол:

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 6.1.3 дахь заалтын “Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан бизнесийн ААНОАТ-ыг 5 хувь болгоно.” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.16 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Ховдын Дөргөн”- “Завханы Загастайн даваа”-ны урд яруугийн уулзвар чиглэлийн 375 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Ховд, Завхан) гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “3,187.50” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.17 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Алтай-Бургастай боомт чиглэлийн 253 км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот

түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “101,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

4. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 2000 км авто зам төслийн бэлэн байдлыг хангах (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн бэлэн байдал” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “17,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.19 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж улс, бүсийн чанартай авто замын сүлжээнд холбох 200 км авто зам барих (Улсын хэмжээнд)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд “100,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

6. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Хожуулын голын гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын

гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “7,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт за гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

7. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.21 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Тосонцэнгэл сумын Идэр голын 96 у/м төмөр бетон гүүр барих (Завхан аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “8,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

8. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.22 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Хүнгүйн голын 72 у/м төмөр бетон гүүр /Завхан, Ургамал сум/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “5,040.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

9. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.2.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Байдрагийн усан цахилгаан станц барих (Баянхонгор аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь

түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “30” гэж, Санхүүжилтэд “54,600.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцах байгууллагад “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.18 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Авто замын засвар арчлалтын ажилд шаардлагатай асфальтбетон завод, тоног төхөөрөмж худалдаж авах /Улсын хэмжээнд/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Тоног, төхөөрөмж” гэж, Хэмжих нэгжид “тоо” гэж, Суурь түвшинд “4” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “4,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Увс аймгийн Малчин сумын Засаг даргын Тамгын газрын барилга барих” Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж тус тус нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.6. дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Үндэсний хиймэл дагуулын дэд бүтцийг байгуулах” гэснийг “Монгол Улсын Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөл хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд

“Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Төслийн хэрэгжилт” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэснийг “75” гэж, Санхүүжилтэд “1,600.00” /Нэг тэрбум зургаан зуун сая/ гэснийг “568,716.33” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Гишүүдийн 63,6 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх” гэснийг “Эмээлт Эко Аж Үйлдвэрийн паркийн дулаан болон цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Цахилгаан хангамжийн барилгын ажлын гүйцэтгэл” гэснийг “Ажлын гүйцэтгэл” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэснийг “25” гэж, Санхүүжилтэд “14,800.00” гэснийг “112,200.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлыг боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “25” гэж, Санхүүжилтэд “85,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвшлийн түншилэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Туул усан цогцолбор барих төслийг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “426,740.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр хувийн хэвшлийн түншилэл, Орон нутгийн төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 13-ыг алгасчихсан байна уу. Тэгвэл буцаад би уншихъя. 13-ыг алгасчих шиг болсон юм. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын 13-ыг түрүүн алгасаад явчихсан учраас одоо би уншъя.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээ хийх, хүний нөөцийн аудитын ажлыг сайжруулах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “1,500.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Төрийн албаны зөвлөл” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал.

17.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэснийг “Гадаадын тусламж, Улсын төсөв” гэж өөрчлөх. Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

18.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.5 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Сэргээгдэх эрчим хүч бүхий дулаан автобусны буудал барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “9,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

19.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.1.2.6 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Гэр хорооллын далан дагуух авто зам төсөл хэрэгжүүлэх /Баянгол дүүргийн 21, 9, 10, 22 дүгээр хороо/” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “10,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.3.3.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Баянгол дүүргийн Цагдаагийн газрын барилга барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “13,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад

“Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Хавдар судлалын Үндэсний төв-II байгуулах” гэснийг “Хавдар судлалын Үндэсний төв-II-ийн дэд бүтэц барилгын ажлыг эхлүүлэх” гэж, Санхүүжилтэд “100,000.00” гэснийг “110,000.00” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.7 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Төр хувийн хэвшлийн түншилэл” гэснийг “Улсын төсөв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

23.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийг “Улсын төсөв” гэснийг “Төр хувийн хэвшлийн түншилэл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт за гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

24.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Яаралтай тусламжийн төв барих (Орхон аймаг)” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “50” гэж, Санхүүжилтэд “5,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагууд “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

25.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2.8 дахь дэд заалтын

Төсөл арга хэмжээнд “Өрх, гэр эрүүл мэндийн төв барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Булган аймаг) гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж, мөн заалтын Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл (Хөвсгөл аймаг) гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “100” гэж, Санхүүжилтэд “2,300.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

26.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.19 дэх дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Мөрөн-Улиастай” чиглэлийн хатуу хучилттай авто зам төсөл барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “10” гэж, Санхүүжилтэд “43,590.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Төр-хувийн хэвшлийн түншилэл” гэж, Хариуцах байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Протоколд тэмдэглээрэй. Батлут гишүүн сүүлийн 2 зарчмын зөрүүтэй саналууд дээрээс дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажиллаагүй байна шүү. Дэмжсэнээр протоколд тэмдэглээрэй.

27.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.3 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээнд “Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэнд хуульчдыг мэргэшүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Мэргэшүүлэх хуульчдын

тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд 2025 онд “20” гэж, Санхүүжилтэд “1,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллагад “ХЗДХЯ” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ санал чинь дэмжигдсэнгүй ээ. Энэ хэнийх Хүрэлбаатар сайдынх эсрэг гарчхаж, минийх бас эсрэг гарчихсан байна. Хүрэлбаатар сайд горимын санал гаргачих. Саяын санал хураалт дээр миний төхөөрөмж ажилласангүй. Би дэмжиж өгсөн эсрэг гарчихлаа. Ийм учраас саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Тэгээд дахин санал хураалт явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна. Санал хураалт. Гишүүд ээ саналаа өгөөрэй. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, саяын горимын санал дэмжигдсэн тул дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ, анхааралтай байгаад саналаа өгөөрэй. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

28.Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулга бүхий дэд заалт шинээр нэмэх:

“4/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүйг ашиглаж, үр дүнг хангахад чиглэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг. Санал хураалт. Одоо нэг найруулгын ганцхан санал байна. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Найруулгын нэг санал байна.

Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсгийн ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх байнгын хорооноос гаргах санал дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг уншиж танилцуулна.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

15.12 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийг оруулаарай.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийнхний танилцуулъя. Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Дунхүүгийн Аюуш Хууль, эрх зүйн газрын захирал, Найманжингийн Ариунбат Банкны бүтэц өөрчлөлт бодлогын газрын захирал.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Тэгвэл асуулт асууж, санал гаргах гишүүд байхгүй байна гээд тасаллаа.

Хуулийн төсөл дээр байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс санал гараагүй тул Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг

дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ундрам танилцуулна.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

15.16 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.
Хэлэлцэх асуудал 3.

Монголбанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлангуудыг хэлэлцэж эхэлье.

Тайлангийн танилцуулгыг Э.Энхтайван дэд ерөнхийлөгч хийх үү. Ажлын хэсгийн 2 номерыг нээе.

Г.Энхтайван: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд 2023 оны Монголбанкны үйл ажиллагааны тайлангийн товч агуулгыг хүргэе. Өнгөрсөн 2023 онд эдийн засгийн сэргэлт бэхжиж, эдийн засагт нааштай эерэг өөрчлөлт гарлаа. Эдийн засгийн өсөлт 7 хувьтай гарч, инфляц 7,9 хувьтай буюу Төв банкны зорилтот түвшинд хүрч бууран урсгал тэнцэл 15

жилийн дараа ашигтай болж, төлбөрийн тэнцлийн ашгаар гадаад валютын албан нөөц нэмэгдэж, төгрөгийн гадаад валюттай харьцах хани чангарсан жил байлаа.

2023 онд гадаад өрийн олон төлбөрийг дотоод нөөц бололцоогоороо амжилттай хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, Монгол Улсын Хөгжлийн банкны Евро бонд, Самуурай бонд, Засгийн газрын Гэрээг бонд, Төв банкны үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хүрээнд авч ашигласан хэлцлийн дүнгээс 1,5 тэрбум юань, хувийн секторын бондын төлбөрүүдийг амжилттай төллөө. Эдгээр том дүнтэй өр төлбөрийг амжилттай төлсөн хэдий ч гадаад валютын албан нөөц 4 тэрбум 920 сая доллар болж нэмэгдлээ.

Харин 2024 оны эхний улиралд эдийн засгийн сэргэлт үргэлжлэн сэргээж ДНБ-ий өсөлт 7,8 хувьтай гарч, 4 дүгээр сарын байдлаар гадаад валютын албан нөөц 5 тэрбум ам.доллар буюу 7 сарын барааны импортын хэмжээг хангах түвшинд хүрч, төгрөгийн гадаад валюттай харьцах хани тогтвортой байж жилийн инфляц улсын хэмжээнд 6,4 хувьд хүрч буурснаар мөнгөний бодлогын төлөвийг бууруулах орон зайг бий болголоо.

Банкны салбарын хувьд эдийн засгийн өсөлтийг дэмжих өрхийн аж ахуйн хэрэглээ хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой хадгалах чиглэлд санхүүгийн зуучлалын үүргээ амжилттай хэрэгжүүлээ. Банкны салбарын хадгаламж жилийн дүнгээр 26,2 хувиар, зээлийн үлдэгдэл 23,3 хувиар өслөө. Банкны салбарын реформ амжилттай үргэлжилж системийн нөлөө бүхий банкнууд бүгд хувьцаагаа хөрөнгийн бирж дээр олон нийтэд нээлттэй арилжаалснаар 470 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж олон нийтэд нээлттэй хувьцаат компани боллоо.

Банкнүүдын кореспондент банкны харилцаанд ахиц дэвшил гарч гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай зардал багатай хийх боломжтой болсон. Банкнүүд анх удаа базэл стандартын дагуу өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлж эхэлсний дээр Төв банкнаас банкны салбарын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн засаглалын эрсдэлийг үнэлэх удирдах аргачлалыг баталлаа.

2024 онд хийхээр төлөвлөсөн ажил их байна. Тухайлбал, Монгол банкны бодлого нь инфляцыг зорилтот түвшинд.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ингээд танилцуулгатай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Сууж байгаарай ажлын хэсгийнхэн. Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монголбанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлангуудыг хэлэлцэж дууслаа.

15.19 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн оруулаарай. Ажлын хэсгийнхэн Даваасүрэн гишүүн байхгүй бол та уншчих уу. Илтгэлийг Засгийн газрын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Хүрэлбаатар танилцуулна. Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе.

Ч.Хүрэлбаатар: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол

Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-д хүний аюулгүй байдал, Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрахад таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй байдлын нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг 3.2-т гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн, өртөгтэй, эрэлтэд нийцсэн байр сууриа хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж тус тус заасан.

Иргэдийг орон сууц худалдан авахад зориулан олгох орон сууцын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн 2013 оноос хойших хугацаанд Засгийн газар, Монголбанк, арилжааны банкнүүдын эх үүсвэрээр 8,1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй орон сууцын зээлийг нийт 122,9 мянган иргэнд олгожээ. Энэ оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 315,7 тэрбум төгрөгийн ипотекийн 6 хувийн зээлийг 2687 зээлдэгчид олгоод байна. Засгийн газраас Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг 6 бүлэг 27 зүйлтэйгээр боловсрууллаа.

Энэхүү хуулийн зорилго нь төрөөс орон сууцыг хөгжүүлэх, санхүүжүүлэх, үндэсний орон сууцын корпорац, орон сууцжуулах санг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, чиг үүргийг тогтоох, хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулалттай холбоотой харилцааг зохицуулахад оршиж байна. Уг хуулийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Хүрэлбаатар сайд баярлалаа. Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Ц.Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрдэнэбулган “Төрийн орон сууцын корпорац” ТӨХХК-ийн захирал, Маргад-Эрдэнэ “Төрийн орон сууцын корпорац” ТӨХХК-ийн Хөрөнгийн ашиглалт, зохицуулалтын газрын дарга, Азжаргал Нийслэлийн орон сууцын бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга, Түвшинтөгс “Нийслэлийн орон сууцын корпорац” ХК-ийн Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа хэлтсийн дарга, Одбаатар Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Цогзолмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын мэргэжилтэн.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримттай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төслийн үзэл баримттай холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Батлут гишүүн та унших уу. Байнгын хорооны санал, дүгнэлтийг өнөөдөр та унших уу. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин танилцуулна.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж өнөөдрийн хурал үүгээр өндөрлөж байна аа. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

15.24 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ